

**ЦЭКАА/202201001 “Цацрагийн хэмжилтийн багаж, тоног төхөөрөмж
нийлүүлэх” тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны хурлын
тэмдэглэл**

№ 03

Цөмийн энергийн комиссын Ажлын албаны даргын А/05 тоот тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо 2022 оны 04-р сарын 12-ны өдрийн 16.00-17.00 цагийн хооронд тус Ажлын албаны хурлын танхимд хуралдав. Хурлыг Үнэлгээний хорооны дарга Э.Нямжав даргалан, үнэлгээний хорооны гишүүн “Хүний хөгжил сургалт судалгааны төв” ТББ-ын гүйцэтгэх захирал Г.Цэрэнжаргал, “Оюуны язгуур” ТББ-ын гүйцэтгэх захирал Н.Ундралмаа, ЦЭК-ын Ажлын албаны мэргэжилтэн М.Түмэнжаргал, үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга А.Золбаяр нарын бүрэлдэхүүнтэй 100 хувийн ирцтэйгээр хуралдлаа.

Хэлэлцэх асуудал:

ЦЭКАА/202201001 “Цацрагийн хэмжилтийн багаж, тоног төхөөрөмж нийлүүлэх” тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны тендерийн материалыг хянан үзэх

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Дарга Э.Нямжав: Энэхүү зарлагдсан тендер шалгаруулалтад “Интерсайнс” ХХК бараа, материал нийлүүлэхээр үнийн санал болон холбогдох баримт материалыг ирүүлсэн бөгөөд тус ирүүлсэн материалд үнэлгээ хийе. Та бүхэн саналаа хэлнэ үү.

Нарийн бичгийн дарга А.Золбаяр: ЦЭКАА/202201001 “Цацрагийн хэмжилтийн багаж, тоног төхөөрөмж нийлүүлэх”-ийг 50,285,000 төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр зарласан бөгөөд тус байгууллагаас ирүүлсэн үнийн санал 69,019,000 төгрөг байгаа нь төсөвт өртгөөс 37 хувиар буюу хол хэтрүүлсэн байна.

Гишүүн Г.Цэрэнжаргал: Түүнээс гадна шаардсан хугацааны санхүүгийн тайланг www.tender.gov.mn цахим хаягийн системд оруулаагүй байгаа тул тендер үнэлэх боломжгүй болж байна. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.4.1-д заасныг үндэслэн тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт дахин явуулах саналтай байна.

Дарга Э.Нямжав: Санал нэг байна. Гишүүдэд өөр санал байна уу ?

Гишүүд: Бүгд санал нэгтэй дэмжиж буйгаа илэрхийлэв.

Дарга Э.Нямжав: Ирүүлсэн тендерийн баримт бичгийг үнэлэхэд ТШӨХ-д заасан шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаагүй тул тендерээс татгалзаж, дахин тендер зарлах саналтай байна. Та бүхэн саналаа хэлнэ үү.

Гишүүд: 100 хувийн саналаар дэмжив.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Тендерт материал ирүүлсэн “Интерсайнс” ХХК-д шаардлагад нийцээгүй тендер ирүүлсэн шалтгааныг албан бичгээр хүргүүлэхээр шийдвэрлэв.


2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.4.1-д заасныг үндэслэн тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт дахин явуулахаар тус тус шийдвэрлэв.

Үнэлгээний хорооны дарга:



Э.Нямжав

Гишүүд:



Г.Цэрэнжаргал

Н.Ундралмаа



М.Түмэнжаргал

Нарийн бичгийн дарга:



А.Золбаяр